

5. БУРХАНЫ ҮГ БОЛ ҮНЭМЛЭХҮЙ

ХЭВЭЭРЭЭ, ХЭЗЭЭ Ч ХУВИРШГҮЙ, МӨНХИЙН, АЛЬФА БА ОМЕГА, ЭХЛЭЛ БА ТӨГСГӨЛ

“Учир нь Миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. Миний зам нь та нарын замаас өөр” гэж ЭЗЭН айлдаж байна. Тэнгэр нь газраас өндөр байдаг шиг, Миний зам та нарын замаас, Миний бодол та нарын бодлоос өндөр билээ.

Бороо, цас тэнгэрээс бууж ирээд, газрыг услахгүйгээр буцдаггүй шиг, (харин газрыг ургуулж цэцэглүүлж, тариачинд үрийг, идэгчид талхыг нь хангадаг.) Миний амнаас гарсан Миний үг хүслийг минь гүйцэтгэхгүйгээр, илгээсэн зорилгыг минь хэрэгжүүлэхгүйгээр Над уруу хоосон буцаж ирэхгүй.

“Учир нь чи баяртайгаар гарч явж, амар тайвнаар хөтлүүлнэ. Уул толгод чиний өмнө баярлан уухайлж, талын бүх модод алга ташицгаана. Өргөст бутны оронд нарс, халгайн оронд мирт л ургана. Энэ бол ЭЗЭНд нэр, үл устах мөнхийн тэмдэг болно”.
(Исаиа 55:8 – 13)

Өвс хатаж, цэцэг гандана. Харин бидний Бурханы үг мөнхөд тогтоно.(Исаиа 40:8)

Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ байна.(Еврей 13:8)

Бурхан бол худал хэлдэг хүн биш, гэмшин харамсдаг хүний хүү ч биш. Тэрээр айлдчихаад, Тэр түүнийгээ хийхгүй гэж үү? Эсвэл Тэр ярьчихаад, Тэр түүнийгээ сайн болгохгүй гэж үү?
(Тооллого 23:19)

Хэрэв бид итгэмжтэй байгаагүй бол, Тэр итгэмжит хэвээрээ байна. Учир нь Тэр Өөрийгөө үгүйсгэж чадахгүй. (2 Тимот 2:13)Өмнө маань тавигдсан найдварыг барьж авахаар хоргодох газар уруу зугтаагч бид Бурханы хувьд худал айлдах боломжгүй хоёр өөрчлөгдөшгүй зүйлээр дамжуулан хүчтэй урам авахын тулд тэгжээ. (Еврей 6:18)

Өөрийн гэрээг би зөрчихгүй, Амнаас гарсан авиагаа өөрчлөхгүй.
(Дуулал 89:34)

ЭЗЭН, Израилийн Хаан, түүний Чөлөөлөгч, түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна. “Би бол эхэн, Би бол эцэс. Надаас өөр Бурхан байхгүй. (Исаиа 44:6)

Би бол Альфа ба Омега, Эхэн ба Эцэс, Эхлэл ба Төгсгөл мөн.
(Илчлэлт 22:13)

[] Энэ дэлхий дээр таньд Бурханы хэтийн төлөвлөгөө би юу?

[] Итгэлээр хэлсэн бүхий л үгс Түүний хүчээр биелэгдэнэ гэдгийг та мэдэх үү?

[] Бурханы Үг мөнхөд оршдог гэдэгт та итгэдэг үү?

[] Та Бурханы шинж чанаруудыг нэрлэж чадах уу?

5.1 ЗӨВТ ШҮҮЛТ

Иймээс иудей хүний давуу тал, эсвэл хөвч хөндөлтийн ашиг нь юу вэ? Аль ч талаараа үлэмж их юм. Бүхнээс өмнө, Бурханы үгс тэдэнд даатгагдсан билээ. Зарим нь итгээгүй бол яах вэ? Тэдний итгэлгүй байдал Бурханы итгэмжит байдлыг хүчингүй болгоно гэж үү? Бүү ийм байх болтугай! Хүн бүр худалч байсан ч Бурхан үнэн байг. Энэ тухай «Та айлдахдаа зөвтгөгдөж Та шүүгдэхдээ ялна» гэж бичигджээ. Хэрэв бидний зөв бус нь Бурханы зөвийг харуулдаг юм бол, бид юу хэлэх билээ? Уур хилэн буулгагч Бурхан нь зөв биш гэж үү? Би хүний ёсоор ярьж байна. Бүү ийм байх болтугай! Тийм бол Бурхан ертөнцийг яаж шүүх юм бэ? Хэрэв миний худал үгээр Бурханы үнэн нь Өөрийнх нь алдар дотор бялхдаг юм бол яагаад би одоо ч гэсэн нүгэлтэн адил шүүгддэг билээ? «“Сайныг гаргахын тулд мууг үйлдэцгээе” гэж ярьж болохгүй гэж үү? Зарим нь биднийг ингэж ярьдаг хэмээн гүтгэн хэлдэг. Тэдний шийтгэл нь шударга юм. (Ром 3:1 – 8)

[] Зөвт бус нь шүүгдэнэ гэдгийг та мэдэх үү?

[] Гэм нүгэл гэж юу болохыг та мэдэх үү?

5.2 ХЭН Ч ЗӨВТ БИШ

Тэгвэл яах вэ? Бид тэднээс давуу юм уу? Огт үгүй. Иудейчүүд болон грекчүүд бүгд нүгэл дор байдаг гэж бид урьд нь ял тулгасан юм.

Энэ нь ингэж бичигдсэнчлэн, «Зөвт хүн алга. Ганц ч алга. Ухаардаг хүн алга. Бурханыг хайдаг хүн алга. Бүгд гажиж, цөмөөрөө хэрэгцээгүй болжээ. Сайныг үйлддэг хүн алга. Бүр ганц ч алга». «Тэдний хоолой нь онгорхой булш юм. Тэд хэлээрээ хуурч мэхэлдэг». «Тэдний уруул дор могойн хор бий». «Тэдний ам хараал болон гашуун үгээр дүүрэн аж». «Тэдний хөл цус урсгахдаа түргэн, тэдний замд сүйрэл болон гай гамшиг бий. Тэд амар амгалангийн замыг мэдэхгүй». «Тэдний нүдний өмнө Бурханаас эмээх айдас үгүй»

Хуулийн хэлж байгаа болгон нь Хуулийн дор байгч хүмүүст хандан ярьдаг гэдгийг бид мэддэг. Ингэснээр ам болгон таглагдаж, ертөнц даяараа Бурханы өмнө буруутгагдах болно. 20 Яагаад гэвэл ямар ч махан бие Хуулийн үйлсээр Түүний өмнө зөвтгөгдөхгүй. Хуулиар нүглийн мэдлэг ирдэг юм. (Ром 3:9 – 20)

[] Түүний өмнө хэрхэн зөвт гэж тооцогдохыг та мэдэх үү?

[] Бузар муу нь яагаад Бурханаас эмээдэггүйг та мэдэх үү?

[] Түүний өмнө бузар муу ба зөвт бус аль аль нь адилхан газар дуусгавар болно гэдгийг та мэдэх үү?

5.3 ЗӨВТ НЬ ИТГЭЛЭЭР ИРДЭГ

Эдүгээ Бурханы зөв нь Хуулиас ангид илэрхийлэгдэв. Үүнийг Хууль ба Эш үзүүлэгчид гэрчилсэн юм. Есүс Христэд итгэх итгэлээр Бурханы зөв нь итгэгч бүх хүнд байна. Ялгаварлал байхгүй. Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй, харин Христ Есүс доторх золилтоор дамжуулан Түүний нигүүлслээр үнэгүй зөвтгөгдсөн билээ. Түүний цусанд итгэх итгэлээр дамжуулан Бурхан Түүнийг эвлэрүүлэл гэж нийтэд харуулав. Ингэсэн нь Бурхан урьд нь үйлдэгдсэн нүглүүдийг тэвчин өнгөрүүлсэн учраас Өөрийнхөө зөвийг илэрхийлэхийн тулд байсан бөгөөд Тэр Өөрөө зөв байж, Есүст итгэгч хүнийг зөвтгөгч байхын төлөө эдүгээ цагт Өөрийнхөө зөвийг илэрхийлэхийн тулд байсан юм. Тэгвэл сайрхал хаана байна? Энэ нь зайлуулагджээ. Ямар хуулиар вэ? Үйлсийнх үү? Үгүй. Харин итгэлийн хуулиар ажээ. Учир нь хүн Хуулийн үйлсээс ангид, итгэлээр зөвтгөгддөг гэж бид үздэг. Эсвэл Бурхан зөвхөн иудейчүүдийнх юм гэж үү? Тэр мөн харь үндэстнүүдийнх биш гэж үү? Тийм ээ, Тэр бас харь үндэстнүүдийнх мөн. Хөвч хөндүүлснийг нь ч итгэлээр, хөвч

хөндүүлээгүйг нь ч итгэлээр зөвтгөх Бурхан бол үнэндээ ганц болой. Тэгвэл бид итгэлээрээ Хуулийг хүчингүй болгох уу? Бүү ийм байх болтугай! Харин ч, бид Хуулийг тогтоодог. (Ром 3:21 – 31)

[] Зөвтийг хэрхэн бий болгохыг та мэдэх үү?

[] Бурхан яагаад хуулийг өгсөнийг та мэдэх үү?

[] Та яагаад итгэлээх зөвтгөгдөж болохыг та мэдэх үү?

5.4 ХЭРХЭН АМЬДРАХ ТАЛААР БҮТЭЭГЧИЙН ЗААВАР

Дараах зүйлийг мэдээсэй гэж Библи өгөгдсөн. Үүнд:

- Та хэн болохыг
- Бурхан хэн болохыг
- Та хаана байгааг
- Та хаашаа явж буйг
- Хэрхэн амьдрахыг

“ Ерөөлийн үүдийг” хэрхэн нээж мөн “ хараалын хаалгыг” хэрхэн хаахыг суралцаж мэдэх

ЭЗЭНий хууль нь төгс төгөлдөр, сэтгэлийг сэргээдэг.

ЭЗЭНий гэрчлэл нь баттай, гэнэнийг ухаантай болгодог. ЭЗЭНий сургаал нь зөв, зүрхийг баярлуулдаг. ЭЗЭНий тушаал нь тодорхой, нүдийг нээж өгдөг.

ЭЗЭНээс эмээхүй нь цэвэр, мөнхөд оршдог. ЭЗЭНий шүүлтүүд үнэн. Тэд бүгдээрээ зөв шударга. Тэд алтнаас, их шижир алтнаас илүү хүсүүштэй, Мөн зөгийн бал, зөгийн сархинагаас дусдаг юмнаас ч илүү чихэрлэг. (Дуулал 19:7 – 10)


- **Хууль:** Амьдралын хэм хэмжээ, хил хязгаар, зөвтийн тодорхойлолт
- **Эзэнээс эмээхүй:** бидэнд энэ нь яагаад хэрэгтэй вэ, цаг үрэхгүй байх, сонгогдогсдын зан чанарыг бүрдүүлэх, айдасгүй байх
- **Гэрчлэл:** буруу, зөвийг ялгах, Бурханы хийсэн зүйлд талархах, дайсныг дийлэх ялалтын замыг мэдэх

- **Тушаал:** харах нүд, яагаад энэ замаар хийх, дайснаас хамгаалах
- **Журам:** зүрх сэтгэлд зориулсан сургамж, яагаад гэдгийн нууц шалтгааныг олох
- **Шүүлт:** туйлын үнэ цэнэ, хуулийн төгс шудрага байдал

Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ. Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм. (Илчлэлт 12:11)

5.5 ДЭЛХИЙ ДЭЭР ХЭРХЭН АМЬДРАХ

Библи нь Түүний хүүхдүүд дэлхий дээр хэрхэн амьдрах болон мөнхийн үр дүн бүхий ерөөлтэй, хангалуун амьдралаар хэрхэн амьдрахыг заадаг.



Тэгээд Есүс дахин тэдэнд —Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Би бол хонины үүд.[Надаас урьд] ирэгсэд бүгд хулгайч, дээрэмчид юм. Харин хонин сүрэг тэднийг сонсоогүй. Би бол үүд мөн. Хэрэв хүн Надаар орвол, тэр аврагдах болно. Орж, гарч, тэжээлээ олно. Хулгайч зөвхөн хулгайлан, алж, сүйтгэхээр ирдэг. Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм. (Иохан 10:7 – 10)

5.6 БУРХАНЫ ҮГ БОЛ МӨНХИЙН

Бурхаы үг бол мөнхийн. Бурханы үгийн дагуу бүтээгдсэн бүх зүйлс нь мөнх юм. Бусад нь зүйлс нь түр зуурынх.

САЙН МЭДЭЭНИЙ АРВАН НУУЦ



БҮХ ЗҮЙЛСИЙГ ТҮҮНЭЭС, ТҮҮГЭЭР ДАМЖУУЛАН, ТҮҮНИЙ ТӨЛӨӨ

Урлаж бүтээсэн / Амийн Модоор бүтээгдсэн бүтээлийн зорилго/Эш үзүүллэгээр дамжуулан илчлэгдсэн /Түүний үгээс зуурч тэтгэгдэх/ Түүний тэнгэр элчүүдээр үйлчлүүлсэн

Учир нь Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс, үзэгдэх ба үл үзэгдэх юмс, хаан ширээнүүд, эсвэл ноёрхлууд, удирдлагууд, эсвэл эрх мэдлүүд ч бүтээгдсэн. Бүх юмс Түүгээр болон Түүний төлөө бүтээгдсэн байна. (Колоссай 1:16)

Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй. (Иохан 1:3)

Тэр ертөнцөд байсан. Ертөнц Түүгээр бий болсон атал, ертөнц Түүнийг таньсангүй. (Иохан 1:10)

эдгээр эцсийн өдрүүдэд Өөрийн Хүүгийн дотор бидэнд хандаж айлдав. Тэр Хүүгээ бүхний өвлөгчөөр томилсон бөгөөд Хүүгээрээ ертөнцийг бүтээсэн билээ. (Еврей 1:2)

Учир нь Түүнээс, Түүгээр, Түүнд бүх юм байна. Түүнд алдар нь үүрд байх болтугай. Амен. (Ром 11:36)

Тэр бол үл үзэгдэгч Бурханы дүр мөн бөгөөд бүх бүтээлийн Ууган нь мөн. Учир нь Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс, үзэгдэх ба үл үзэгдэх юмс, хаан ширээнүүд, эсвэл ноёрхлууд, удирдлагууд, эсвэл эрх мэдлүүд ч бүтээгдсэн. Бүх юмс Түүгээр болон Түүний төлөө бүтээгдсэн байна. Тэр бүх юмсын урьд байна. Бүх юмс Түүний дотор оршин тогтнодог. Тэр мөн бие болох чуулганы тэргүүн мөн. Тэр бол эхлэл мөн, үхэгсдээс анх төрсөн нь мөн. Энэ нь Тэр Өөрөө бүх юмсын тэргүүн болохын тулд юм. (Колоссай 1:15 – 18)